

23 МЕССИА: ДАХИН ИРЭЛТ

23.1 Байр бэлтгэх

¹⁰Тэр өдөр Иессийн үндэс ард түмний туг мэт босож, үүнийг тойрон үндэстнүүд цуглаж, алдар нь Түүний амрах газар болно. (Исаиа 11:10 АБ 2004)

¹Та нар зүрхээ бүү зовоо. Бурханд итгэ, мөн Надад итгэ. ²Миний Эцэгийн гэрт орон байр олон бий. Хэрэв тийм биш байсан бол Би та нарт хэлэх байсан. Би та нарт орон байр бэлдэхээр явна. ³Хэрэв Би явж та нарт орон байр бэлдвэл, дахин ирж, та нарыг Өөртөө авна. Би хаана байна, та нар мөн тэнд байх болно. ⁴[Миний] явах газарт очих замыг та нар мэднэ гэж айлдав. (Иохан 14:1-4 АБ 2004)

23.2 Сэргээн босгогч / Сэргээн засварлагч

⁴Тэгээд эртний балгаснуудыг сэргээн босгож, урьдын эвдэрсэн газруудыг янзалж, олон үеийн туршид хоосорч сүйрсэн хотуудыг шинэчлэн засварлана. ⁵Харь хүмүүс босож, та нарын сүргүүдийг хариулна. Харийн хөвгүүд та нарын тариаланч, усан үзэмчид болцгооно.

⁶Харин та нар ЭЗЭНий тахилч нар, бидний Бурханы үйлчлэгчид гэж нэрлэгдэн, үндэстнүүдийн эд баялгийг идэн, тэдний хөрөнгөөр сайрхах болно. ⁷Ичгүүрийнхээ оронд та нар хоёр дахин их хувийг авч, доромжлолын оронд тэд өөрсдийнхөө хувьд баярлан хашхирна. Тийм учраас тэд өөрсдийн газартаа хоёр дахин ихийг эзэмшин, мөнхийн баяр баясгалан тэднийх болно. (Исаиа 61:4-7 АБ 2004)

¹²Танай хүмүүс эрт цагт эвдэрсэн балгаснуудыг дахин сэргээн, олон үеийн сууриудыг босгоно. Тэгээд чамайг “Цөмөрхийг сэргээн босгогч, оршин суух гудамжийг засагч” гэж нэрлэнэ. (Исаиа 58:12 АБ 2004)

[] Та сэргээн босгогч, сэргээн засварлагч байхаар дуудагдсан уу?

23.3 Сэргээх

¹⁰“Одоо Би босно” гэж ЭЗЭН айлдаж байна. “Одоо Би өргөмжлөгдөнө. Одоо Би өргөгдөнө. ¹¹Та нар өвсөөр

жирэмсэлж, сүрэл төрүүлнэ. Амьсгал чинь та нарыг гал мэт шатаана. ¹²Хүмүүс нь далдуу мод мэт, галд шатаж буй тастагдсан үүргэнэ мэт шатна.

¹³Холынхон та нар, Миний юу хийснийг сонсож, ойрынхон та нар, Миний хүчийг мэдэгтүн” гэв.

¹⁴Сион дахь нүгэлтнүүд айж, бурхангүй хүмүүс түгшүүрт автав. “Бидний хэн маань түймэрдэгч галын дотор амьдарч чадах вэ? Бидний хэн нь мөнхөд шатсаар амьдарч чадах вэ?”

¹⁵Зөв шударгаар явж, үнэнийг өгүүлж, шударга бус олзыг жигшиж, хахууль авахаас гараа хол байлган, цус урсгах талаар сонсохгүйн тулд чихээ бөглөн, мууг үзэхгүйн тулд нүдээ аньдаг ¹⁶хүн өндөрт заларч, түүний хоргодох газар нь хадан бэхлэлт байх болно. Түүнд талхыг нь өгч, ус нь элбэг байх болно. ¹⁷Чиний нүд гоо үзэсгэлэнт Хааныг харж, тэд алс холын газрыг үзнэ.

¹⁸Чиний зүрх “Тооллого хийгч хаана байна? Татвар хураагч хаа байна? Цамхаг хянагч хаа байна?” гэж аюулыг тунгаан бодно. ¹⁹Хэн ч ойлгохгүй бэрх яриатай, хэн ч үл ойлгох харь хэлтэй догшин хүмүүсийг чи цаашид харахгүй.

²⁰Манай баяр наадмын хот Сионыг харагтун. Энх амгалангийн орон, гадаснууд нь хэзээ ч сугарахгүй, нэг ч аргамж нь тасрахгүй, эвхэгдэхгүй майхан болон Иерусалимыг үзнэ. ²¹Тэнд цог жавхланта Нэгэн болох ЭЗЭН бидний төлөө байх болно. Ингэхдээ гол, өргөн сувгийн газар мэт болж, түүгээр сэлүүрт завь хийгээд усан онгоц ч өнгөрөхгүй. ²²Учир нь ЭЗЭН бол бидний шүүгч, ЭЗЭН бол бидний хууль тогтоогч, ЭЗЭН бол бидний хаан мөн бөгөөд Тэр биднийг аварна.

²³Чиний аргамж тайлагдаж, шургийн суурь нь уягдахгүй, дарвуул дэлгэж чадахгүй. Тэр үед тансаг их олз омог чинь хуваагдаж, доголон хүн ч хувь хүртэнэ. ²⁴“Би өвчтэй байна” гэж нэг ч оршин суугч өгүүлэхгүй. Тэнд амьдарч байгаа хүмүүсийн нүгэл нь уучлагдах болно. (Исаиа 33:10-24 АБ 2004)

[] Хууль тогтоогч, Мөнхийн Хааныг та хувьчлан мэдэх үү?

23.4 Цэвэршүүлэлт

⁹Гурав дахь хэсгийг нь Би гал дундуур гарган, мөнгийг цэвэршүүлдэг шиг тэднийг цэвэршүүлж, алтыг тунгаадаг шиг тэднийг тунгаана. Тэд Миний нэрийг дуудаж, Би тэдэнд хариулах болно. “Тэд бол Миний ард түмэн” гэж Би айлдан, “ЭЗЭН бол миний Бурхан” гэж тэд хэлнэ”. (Зехариа 13:9 АБ 2004)

¹⁰Би нигүүлслийн, гуйлтын Сүнсийг Давидын гэр дээр, Иерусалимын оршин суугчид дээр асгана. Тэгснээр тэд өөрсдийн жадалсан Намайг харна. Тэд ганц хүүгийнхээ төлөө гашуудаж буй нэгэн мэт Түүний төлөө гашуудан, ууган хүүгийнхээ хойноос асгартал уйлдаг шиг Түүний хойноос асгартал уйлах болно. (Зехариа 12:10 АБ 2004)

[] Жинхэнэ ёсоор гэмших нь бүх бэрхшээлийн хариу гэдгийг та мэдэх үү?

23.5 Хиймэл шүтээнүүдийн нэрийг хориглох

²“Тэр өдөр ийм зүйл болно” гэж түмэн цэргийн ЭЗЭН тунхаглаад “Би шүтээнүүдийн нэрсийг тэр нутгаас тастах болно. Тэд цаашид дурсагдахгүй. Би мөн эш үзүүлэгчид болон бузар сүнсийг тэр нутгаас зайлуулна. (Зехариа 13:2 АБ 2004)

[] Хэзээ ийм зүйл болохыг та мэдэх үү?

23.6 Шалгагдсан булангийн үнэт чулуу

¹Миний өргөмжилсөн Зарц, Миний сэтгэлд таалагддаг Миний сонгосон нэгнийг харагтун. Би Түүний дээр Өөрийн Сүнсийг тавина. Тэр үндэстнүүдэд шударга ёсыг авчирна. (Исаиа 42:1 АБ 2004)

¹⁶Тийм учраас Эзэн БУРХАН “Үзэгтүн. Би Сионд нэг чулууг тавина. Тэр нь шалгагдсан бөгөөд бат тавигдсан суурийн булангийн үнэт чулуу юм. Түүнд итгэгчийг яаруулахгүй. ¹⁷Би шударга ёсыг хэмжих шугам болгон, үнэн зөвийг түвшин

болгоно. Худлын хоргодох газрыг мэндрөөр арчин, нууц газрыг усаар нөмөргөнө.

¹⁸Та нарын үхэлтэй байгуулсан гэрээ, Үхэгсдийн оронтой тохиролцсон хэлэлцээр нь хүчингүй болно. Дийлдэшгүй ташуур дайран өнгөрөхдөө та нарыг гишгэчин дэвслэх болно. ¹⁹Тэр өнгөрөх бүрдээ та нарыг барина. Өглөө бүр, өдөр шөнөгүй дайран өнгөрнө.

Энэ мэдээг ойлгох нь үнэхээр аймшигтай байх болно” гэж айлдаж байна. ²⁰Сунаж хэвтэхэд ор нь хэт богино, биеэ хучихад хөнжил нь хэт нарийн ажээ. ²¹ЭЗЭН Перазим уулан дээр боссон шиг босож, Гибсоны хөндийд хилэгнэсэн шиг хилэгнэн, Өөрийн үйлийг, ер бусын үйлийг үйлдэнэ. Тэр Өөрийн ажил, гайхамшигт ажлыг хийнэ. ²²Элэглэхээ одоо зогсогтун. Эс тэгвэл та нарын гинж чангарна. Учир нь бүх дэлхий дээрх тогтоогдсон сүйрлийг түмэн цэргийн Эзэн БУРХАНаас би сонсов. (Исаиа 28:16-22 АБ 2004)

[] Бурханы үйлчлэгч гэж хэн болохыг та мэдэх үү?

23.7 Олон үндэстэн Эзэнтэй нэгдсэн

¹¹“Тэр өдөр олон үндэстнүүд өөрсдийгөө ЭЗЭНтэй холбож, Миний ард түмэн болно. Тэгээд Би та нарын дунд оршиж, түмэн цэргийн ЭЗЭН Намайг та нар уруу илгээснийг та нар мэдэх болно. (Зехариа 2:11 АБ 2004)

⁵ЭЗЭН тунхаглаж байна. “Би хотыг хүрээлэн галт хана болно. Би түүний дундах алдар нь байх болно” гэв. (Зехариа 2:5 АБ 2004)

[] Та эдгээр үндэстнүүдийн төлөө одоо залбирдаг уу?

[] Та Бурханы Үг нь хүмүүстэй уулзахын тулд Иерусалим уруу илжиг унаж орсныг мэдэх үү?

23.8 Үндэстнүүдийн дунд өргөмжлөгдсөн

¹⁰Тэмцэлдэхээ больж, намайг Бурхан гэдгийг мэд. Би улс үндэстнүүдийн дунд өргөмжлөгдөнө, Би дэлхийд өргөмжлөгдөнө. (Дуулал 46:10 АБ 2004)

¹⁰Би ЭЗЭНий дотор ихэд бахдан,
сэтгэл минь миний Бурханд баярлана.
Сүйт залуу өөрийгөө цэцгийн хэлхээгээр чимж,
сүйт бүсгүй өөрийгөө үнэт чулуугаар гоёдог шиг,
Тэр намайг үнэн зөвийн нөмрөгөөр ороож,
авралын хувцсаар хувцасласан юм.

¹¹Учир нь газар дэлхий мөчир нахиа ургуулан,
цэцэрлэг дотор нь тарьсан юмсыг ургуулдаг шиг
Эзэн БУРХАН бүх үндэстний өмнө үнэн зөв ба магтаалыг
бий болгоно. (Исаиа 61:10-11 АБ 2004)

[] Та Христ дотор баярладаг уу?

23.9 Хоньчин

¹⁵Тэгээд та нарыг мэдлэг, оюун ухаанаар тэжээх, Миний
Өөрийн зүрхийг дагадаг хоньчдыг Би та нарт өгнө. (Исаиа
61:10-11 АБ 2004)

23.10 Зөв шударга засаглал

¹Үзэгтүн, хаан нь үнэн зөвөөр хаанчлан, ноёд нь шударгаар
захирна.

²Хүн бүр салхинаас хоргодох газар мэт, шуурганаас халхлах
халхавч мэт, хуурай газрын усны суваг мэт, ангасан газар
дахь өндөр хадны сүүдэр мэт байх болно.

³Тэгээд хараатай хүмүүсийн нүд нь сохрохгүй, сонсох чихтэй
нь сонсох болно.⁴Адгуу хүний зүрх мэдлэгийг ялган таньж,
хэлгий хүний хэл нь тод ярих гэж яарна. ⁵Цаашид тэнэгийг
сурвалжит хүн гэж дуудахгүй, зальт этгээдийг өглөгч
гэхгүй.⁶Учир нь тэнэг хүн утгагүй юм ярьдаг ба түүний зүрх
нь балмад хэргийг үйлддэг. Тэр өлсгөлөн хүний сэтгэлийг
хоосруулж, ундаасагчийг ундаар дутагдуулахын тулд
ЭЗЭНий эсрэг буруу ярьж, бурхангүй явдлыг үйлддэг.⁷Зальт
этгээдүүдийн хувьд тэдний зэвсэг нь бузар муу билээ.
Хэдийгээр ядуу нэгэн шударгыг яривч, худал хуурмаг үгсээр
үгээгүйчүүдийг хөнөөхийн тулд тэрээр хорт муу арга
зохиодог.

⁸Харин сурвалжит хүн зөв шударгаар сэтгэж, түүгээрээ
тогтдог. (Исаиа 32:1-8 АБ 2004)

¹¹Бурууг үйлддэг нэгэн нь буруугаа үйлдсээр л байг. Бузар муу нэгэн нь бузар муу чигээрээ л байг. Зөвт нэгэн нь зөвт байдлаа хэрэгжүүлсээр л байг. Ариун нэгэн нь өөрийгөө ариунаар сахисаар л байг. (Илчлэлт 22:11 АБ 2004)

⁹Амарлингуй эмс ээ. Босож, миний дуу хоолойг сонсогтун. Ихэрхүү охид оо, миний үгэнд чих тавигтун. ¹⁰Жил гаруйхны дотор ихэрхүү та нар зовох болно. Учир нь усан үзмийн ургац хураалт төгсөж, жимс хураалт болохгүй.

¹¹Амарлингуй эмс ээ, чичрэгтүн. Бардам охид оо, зовогтун. Хувцсаа тайлан нүцгэлж, бэлхүүсээрээ таар ороогтун. ¹²Үржилтэй талбай, шүүслэг усан үзмийн төлөө цээжээ дэлдэгтүн. ¹³Миний ард түмний нутаг, үүргэнэ ба өргөст халгай ургасан нутаг, баясгалант хот ба бүх жаргалтай гэрүүдийн төлөө гашуудагтун.

¹⁴Учир нь орд харш хаягдан, их шуугиант хот мартагдан, хэрэм цамхгууд нь үүрд малын бэлчээр, хулангуудын хороо болно. ¹⁵Өндрөөс, бидний дээрээс Сүнс цутгах хүртэл, зэлүүд газар нь үржил шимтэй талбай болж, үржил шимтэй талбай нь ой мод хэмээн тооцогдох хүртэл тийм байх болно. ¹⁶Тэгээд шударга ёс нь цөлд оршиж, үнэн зөв нь үржилтэй талбайд байна.

¹⁷Үнэн зөвийн үйлс нь амар тайван байж, үнэн зөвийн үйлчлэл нь үүрдийн амар амгалан, аюулгүй байдал болох юм. ¹⁸Миний ард түмэн энх амгалан орчинд, аюулгүй гэрүүдэд, анир чимээгүй газарт амьдарна. ¹⁹Ойд мөндөр орж, хот доош оруулагдсан боловч, ²⁰бүх усны дэргэд тариа тарьж, шар, илжгээ чөлөөтэй идээшлүүлэгчид та нар ямар ивээлтэй байх вэ! (Исаиа 32:9-20 АБ 2004)

[] Бүхний төлөө шударга ёсны цаг ирж байна гэдэгт та итгэдэг үү?

23.11 Хаадын хаан ба Эзэдийн Эзэн

¹¹Би тэнгэр нээгдсэнийг харлаа. Харагтун, тэнд цагаан зүсмийн морь байлаа. Түүн дээр суусан нь “Итгэмжит бөгөөд Үнэн” гэсэн нэртэй бөгөөд зөв шударгаараа шүүж дайтдаг. ¹²Түүний мэлмий нь галын дөл шиг, тэргүүн дээр нь олон титэм байна. Өөрөөс нь өөр хэн ч мэдэхгүй нэр дээр нь бичээстэй байлаа. ¹³Тэр цусанд дүрэгдсэн дээл өмсжээ.

Түүний нэрийг “Бурханы Үг” гэдэг ажээ. ¹⁴Цагаан өнгөтэй цэвэрхэн, нарийн маалинган хувцас өмссөн, тэнгэр дэх дайчид цагаан зүсмийн морьд унан Түүнийг дагаж байв. ¹⁵Түүний амнаас нь хурц сэлэм цухуйх агаад түүгээр Тэр үндэстнүүдийг устгах юм. Тэр үндэстнүүдийг төмөр таягаар захирах болно. Тэрээр Төгс хүчит Бурханы догшин уур хилэнгийн дарсан шахуургыг шахна. ¹⁶Тэр дээл болон гуян дээрээ “Хаадын Хаан, эздийн Эзэн” гэж бичсэн нэртэй ажээ. (Илчлэлт 19: 11-16 АБ 2004)

23.12 Найр

²⁹Харин Би та нарт хэлье. Үүнээс хойш Би энэ усан үзмийн дарсыг та нартай хамт Эцэгийнхээ хаанчлалд дахин шинээр уух өдрийг хүртэл ер уухгүй гэв. (Матай 26: 29 АБ 2004)

⁶Түмэн цэргийн ЭЗЭН энэхүү уулан дээрх бүх хүнд хуучин дарс, хамгийн сайн мах ба дарс бүхий элбэг дэлбэг найрыг хийхээр бэлтгэнэ.

⁷Энэ уулан дээр Тэр бүх хүмүүсийн дээгүүрх бүтээлгийг, бүх үндэстний дээгүүр татсан хөшгийг залгина.

⁸Тэр үхлийг мөнхөд залгина. Эзэн БУРХАН бүх нүүрнээс нулимсыг арчин, Өөрийн хүмүүсийн зэмлэлийг бүх дэлхийгээс зайлуулна. (Исаиа 25: 6-8 АБ 2004)

23.13 Цаг хугацаа

⁶Тэр надад -Эдгээр үгс нь итгэмжит бөгөөд үнэн. Эш үзүүлэгчдийн сүнсний Бурхан Эзэн удахгүй болох ёстой зүйлсийг Өөрийн зарц нартаа үзүүлэхийн тулд тэнгэр элчээ илгээв.

⁷“Харагтун, Би удахгүй ирнэ. Энэхүү номын эш үзүүлэлгийн үгсийг сахигч нь ерөөлтэй еэ!” гэсэн гэж хэлэв. ⁸Иохан, би бол эдгээр зүйлсийг үзэж, сонссон нэгэн юм. Би үзэж, сонсоод эдгээр зүйлсийг надад үзүүлсэн тэнгэр элчид мөргөхөөр хөлд нь унав.

⁹Тэр надад -Ингэсний хэрэггүй. Би бол чиний болон эш үзүүлэгч ах дүүсийн чинь, мөн энэхүү номын үгсийг

сахигсдын хамтран зүтгэгч боол билээ. Бурханд мөргөгэв. ¹⁰Тэр надад ингэж хэлэв.

-Энэхүү номын эш үзүүллэгийн үгсийг бүү лацад. Учир нь цаг ойрхон байна. ¹¹Бурууг үйлддэг нэгэн нь буруугаа үйлдсээр л байг. Бузар муу нэгэн нь бузар муу чигээрээ л байг. Зөвт нэгэн нь зөвт байдлаа хэрэгжүүлсээр л байг. Ариун нэгэн нь өөрийгөө ариунаар сахисаар л байг. (Илчлэлт 22: 6-11 АБ 2004)

¹²Харагтун, Би удахгүй ирнэ. Хүн бүрд үйлдсэнийх нь дагуу буцаан төлөхийн тулд Миний шагнал Надтай хамт байгаа. ¹³Би бол Альфа ба Омега, Эхэн ба Эцэс, Эхлэл ба Төгсгөл мөн. ¹⁴Амийн мод уруу очих эрхтэй болохын тулд болон хаалгаар хот уруу орохын тулд дээлээ угаагчид нь ерөөлтэй еэ!

¹⁵Гадна талд нь ноход, мэргэ төлөгчид, завхай хүмүүс, алуурчид, шүтээнд мөргөгчид болоод худлыг хайрладаг, үйлддэг бүхэн байна. ¹⁶Есүс Би уулгануудын төлөө та нарт эдгээр зүйлийг гэрчлэхийн тулд Өөрийн тэнгэр элчийг илгээлээ. Би бол Давидын Удам ба Үндэс, гэрэлт үүрийн цолмон билээ гэв. ¹⁷Сүнс болон сүйт бүсгүй -Ирээрэй гэнэ. Сонсогч нь -Ирээрэй гэж хэлэг. Цангасан нэгэн нь ирэг. Хүссэн нэгэн нь амийн усыг үнэгүй аваг. (Илчлэлт 22: 12-17 АБ 2004)

²⁰Эдгээр зүйлсийг гэрчлэгч Тэр -Тийм ээ, Би удахгүй ирнэ гэж айлдаж байна. Амен. Ирээрэй, Эзэн Есүс ээ! ²¹Эзэн Есүсийн нигүүлсэл бүгдтэй хамт байх болтугай. Амен. (Илчлэлт 22: 20-21 АБ 2004)

[] Та сонссон зүйлээ сахидаг уу?

[] «Энэ нь тийм байг » гэж юу болохыг та мэдэх үү?

[] Таньд ямар шагнал байгааг Бурхан мэддэгийг та мэдэх үү?

[] Та Түүний дахин ирэхийг хүсэн хүлээдэг үү?

23.14 Есүсийн бэлтгэсэн шагнал

¹²Харагтун, Би удахгүй ирнэ. Хүн бүрд үйлдсэнийх нь дагуу буцаан төлөхийн тулд Миний шагнал Надтай хамт байгаа. ¹³Би бол Альфа ба Омега, Эхэн ба Эцэс, Эхлэл ба Төгсгөл мөн.

¹⁴Амийн мод уруу очих эрхтэй болохын тулд болон хаалгаар хот уруу орохын тулд дээлээ угаагчид нь ерөөлтэй еэ!
(Илчлэлт 22: 12-14 АБ 2004)

⁵Сэнтийд Залрагч -Харагтун, Би бүх юмсыг шинэ болгож байна гээд Бичигтүн, эдгээр үгс итгэмжит бөгөөд үнэн гэв. ⁶Тэр надад -Биеллээ. Би бол Альфа ба Омега, Эхлэл ба Төгсгөл. Цангасан нэгэнд Би амийн усны булгаас үнэгүй өгнө. ⁷Ялагч нь эдгээр зүйлийг өвлөх бөгөөд Би түүний Бурхан болж, тэр Миний хүү болно. ⁸Харин хулчгар, итгэлгүй, жигшүүрт, алуурчид, завхай хүмүүс, мэргэ төлөгчид, шүтээнд мөргөгчид болон бүх худалч хүмүүсийн хувьд, тэдэнд оногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуурт байна гэв.(Илчлэлт 21: 5-7 АБ 2004)

[] Та амийн усыг хүсдэг үү?

[] Та шинэ хүмүүсийн нэг мөн үү?

23.15 Би удахгүй ирнэ

¹²Харагтун, Би удахгүй ирнэ. Хүн бүрд үйлдсэнийх нь дагуу буцаан төлөхийн тулд Миний шагнал Надтай хамт байгаа. ¹³Би бол Альфа ба Омега, Эхэн ба Эцэс, Эхлэл ба Төгсгөл мөн. ¹⁴Амийн мод уруу очих эрхтэй болохын тулд болон хаалгаар хот уруу орохын тулд дээлээ угаагчид нь ерөөлтэй еэ! ¹⁵Гадна талд нь ноход, мэргэ төлөгчид, завхай хүмүүс, алуурчид, шүтээнд мөргөгчид болоод худлыг хайрладаг, үйлддэг бүхэн байна.

¹⁶Есүс Би чуулгануудын төлөө та нарт эдгээр зүйлийг гэрчлэхийн тулд Өөрийн тэнгэр элчийг илгээлээ. Би бол Давидын Удам ба Үндэс, гэрэлт үүрийн цолмон билээ гэв. (Илчлэлт 22: 12-16 АБ 2004)

[] Та Бурханы Үгэнд дуулгавартай байдаг уу?

[] Та зөвт байдлаа үргэлжлүүлж байна уу?

[] Та өдөр бүр зөв шударгын хувцсаа угаадаг уу?

23.16 Ирж тэдэнтэй хамт оршин суух

¹⁰Сионы охин оо! Баярлан дуулж, баясагтун. Үзтүгэй, Би ирж байна. Би та нарын дунд орших болно” гэж ЭЗЭН тунхаглаж байна. (Зехариа 2: 10 АБ 2004)

23.17 Эхэн ба Эцэс, Альфа ба Омега

⁷Харагтун, Тэр үүлсийн хамт ирэх бөгөөд нүд бүр Түүнийг харна. Тэр байтугай Түүнийг жадалсан хүмүүс ч харна. Дэлхийн бүх овог Түүнээс болж гашуудах болно. Тийм ээ, Амен.

⁸-Би бол байгаа болон байсан, мөн хожим ирэх Төгс хүчит Альфа ба Омега гэж Эзэн Бурхан айлдаж байна. (Илчлэлт 1: 7-8 АБ 2004)

[] Та шинэ амьдралаа эхэлсэн үү?

[] Амьдрал тань хэзээ дуусахыг та урьдчилан хэлж чадах уу?

23.18 Шинэ Тэнгэр ба Шинэ Газар

¹Би шинэ тэнгэр, шинэ газрыг харлаа. Учир нь анхны тэнгэр, анхны газар нь өнгөрөн одож, тэнгис байхгүй болов.

²Ариун хот, шинэ Иерусалим нь нөхөртөө очихоор гоёсон сүйт бүсгүй мэт бэлтгэгдэн Бурханаас гарч, тэнгэрээс буун ирэхийг би харлаа. ³Сэнтийнээс чанга дуу гарахыг би сонсов. -Харагтун, Бурханы асар хүмүүсийн дунд байна. Тэр тэдний дунд нутаглах болно. Тэд Түүний ард түмэн болж, Бурхан Өөрөө тэдний дунд байж [тэдний Бурхан нь болно]. ⁴Тэр тэдний нүднээс нулимс бүрийг нь арчина. Тэнд цаашид үхэл байхгүй болно. Тэнд цаашид гашуудах, уйлах, өвдөх гэж үгүй болно. Анхны юмс өнгөрөн одлоо. ⁵Сэнтийд Залрагч -Харагтун, Би бүх юмсыг шинэ болгож байна гээд -Бичигтүн, эдгээр үгс итгэмжит бөгөөд үнэн гэв. ⁶Тэр надад -Биеллээ. Би бол Альфа ба Омега, Эхлэл ба Төгсгөл. Цангасан нэгэнд Би амийн усны булгаас үнэгүй өгнө. ⁷Ялагч нь эдгээр зүйлийг

өвлөх бөгөөд Би түүний Бурхан болж, тэр Миний хүү болно.⁸ Харин хулчгар, итгэлгүй, жигшүүрт, алуурчид, завхай хүмүүс, мэргэ төлөгчид, шүтээнд мөргөгчид болон бүх худалч хүмүүсийн хувьд, тэдэнд оногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуурт байна гэв.
(Илчлэлт 21:1-8 АБ 2004)

[] Та өнөөгийн дэлхийн хувь заяаг болон үүн дээр хийгдэх бүх зүйлийг мэдэх үү?

[] Та үүнийг (Бурханы асар) ирээсэй хэмээн хүсэн хүлээж байна уу?